

## Гарчиг

Судалгааны гол агуулга, зорилго	.....4
Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт	.....5-6
Бүлэг 1. Хүн ам зүйн байдал	.....7
1.1 Хүн амын тооны өсөлт, өөрчлөлт	.....7
1.2 Хүн ам, өрхийн тоо, байршлаар, сумаар	.....8
1.3 Хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд	.....9
1.4 Дундаж наслалт	.....11
1.5 Хөдөлмөрийн насны 1000 хүн амд ногдох хүүхэд, өндөр настай хүний тоо	.....11
1.6 Нийгмийн зарим үзүүлэлтүүд	.....12
Бүлэг 2. Хүн амын ердийн хөдөлгөөн	.....13
2.1 Төрөлт, нас баралт, цэвэр өсөлт	.....13
2.2 Гэрлэлт, цуцлалт, үрчлэлт	.....15
Бүлэг 3. Хүн амын дотоод шилжих хөдөлгөөн	.....17
3.1 Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал	.....18
3.2 Шилжин ирэлт	.....18
3.3 Шилжэн явалт	.....19
3.4 Хүн амын цэвэр шилжих хөдөлгөөн	.....19
Дүгнэлт	.....21

**Танилцуулгыг хянан, тохиосон:**

Т.Эрдэнэбат

**Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:**

О.Ундрах

---

**Хаяг:** Нутгийн удирдлагын ордон, Өрөө 103, 103а

Утас: 70518819, 70518203

Цахим хаяг: [statistic\\_suh@yahoo.com](mailto:statistic_suh@yahoo.com)

Веб хаяг: [www.nso.mn](http://www.nso.mn)

[www.1212.mn](http://www.1212.mn)

Сүхбаатар аймгийн Статистикийн хэлтэс

Баруун-Урт сум, 2012 он

## **ХҮН АМЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, СУДАЛГААНЫ ГОЛ АГУУЛГА, ЗОРИЛГО**

1996 онд “Монгол улсын төрөөс баримтлах хүн амын бодлогод” Монгол улс хүн амаа тогтвортой өсгөж, хүн амын жилийн дундаж өсөлтийг 1.8 хувиас бууруулахгүй гэсэн зорилт тавьсан. Монгол Улсын өнөөгийн байдал нь төрөлтийг нэмэгдүүлснээр хүн амын өсөлтийг бий болгох хангалттай түвшинд хүртлээ хөгжөөгүй байгаа учраас энэхүү бодлогын баримт бичгийг 2004 онд шинэчлэн өөрчилсөн бөгөөд хүн амын өсөлтийн талаар тодорхой тоон зорилт дэвшүүлээгүй бөгөөд харин хүн амын тоо болон бүтцийн өөрчлөлтөд шууд нөлөөлөгч хүчин зүйл болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний асуудлыг цогцоор нь авч үзсэн. Энэ бодлогод хүний нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэсэн чөлөөт сонголт бүхий зохистой төрөлтийг дэмжиж өвчлөл, нас баралтыг бууруулах замаар хүн амын тогтвортой өсөлтийг хангана гэж заажээ. “Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах хүн амын бодлого”-ын гол зорилго нь хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн ардаа урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчныг бүрдүүлэхэд оршиж байна.

Уг бодлогыг үндэслэн Сүхбаатар аймгийн хүн ам зүйн үзүүлэлтүүдийн өнөөгийн түвшин, Монгол улсын хэмжээнд ямар түвшинд явж байгаа, хүн ам зүйн өсөлт, шилжих хөдөлгөөний хандлага, хүн ам зүйн ачаалал, нийгмийн хамгаалал, ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшинг сүүлийн 5 жилээр харьцуулан тооцож, үнэлэлт дүгнэлт өгөхөд орших ба тус аймгийн удирдлага болон хэрэглэгчдийг хүн ам, өрхийн дэлгэрэнгүй мэдээллээр хангах зорилготой болно. Хүн амын тогтвортой өсөлтийн хангах гол үзүүлэлт бол хүн амын цэвэр өсөлт мөн.

Улсын нийгэм эдийн засгийн хөгжил нь тухайн орны хүн ам зүйн бодлогоо хэрхэн боловсруулж, яаж хэрэгжүүлэхээс шууд шалтгаална.

Эдийн засгийн хөгжил нь хүн амын тоо, насны бүтэц, өсөлтийн түвшингээс шууд хамаарч байдаг. Тиймээс хүн амын өсөлт, насны бүтэц, байршил болон түүнд гарч буй өөрчлөлтүүдийг сүүлийн таван жилээр харуулж, харьцуулсан судалгааг хийхийг зорьлоо.

## **НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ:**

**Суурин хүн ам:** Тухайн засаг захиргааны нэгжид 183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа бүх хүнийг суурин хүн ам гэнэ. Мөн 6 сараас доош хугацаагаар түр эзгүй байгаа байнга оршин суудаг хүмүүсийг суурин хүн амын бүртгэлд оруулна.

**Өрх:** Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн болон гэр бүлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.

**Нэг өрхөд ноогдох хүний тоо:** Нэг өрхөд ноогдох хүний тоог тодорхойлохдоо өрхөд тоологдсон хүний тоог өрхийн тоонд харьцуулна.

**Хүйсийн харьцаа:** Хүйсийн харьцаа гэсэн үзүүлэлт нь 100 эмэгтэйд ноогдох эрэгтэйчүүдийн тоог илэрхийлдэг.

**Хүн ам зүйн ачаалал:** Хөдөлмөрийн насны 100 хүнд ноогдох тэжээлгэгчийн тоог харуулдаг.

**Насны голч:** Хүн амыг нас бүтцийх нь хувьд яг голлон хувааж байгаа насыг насны голч гэнэ.

**Хүн амын нас-хүйсийн суварга:** Судалгаанд хүн амын нас, хүйсийн суваргаар нас, хүйсийн бүтцийг зураглан харуулдаг. Энэ нь зэрэгцүүлэхэд хялбар, хүйсийн ялгавраар төв абцисс тэнхлэгээс хамгийн залуугаас эхлэн насны өсөх дарааллаар, доороос дээш суварган хэлбэртэй байна. Нас, хүйсний бүлэг бүр 100 хувьтай тэнцүү байна.

**Өрх толгойлсон эмэгтэйчүүд:** Нөхөргүй, өрх толгойлон амьдарч байгаа эмэгтэйчүүдийг хүүхэдтэй эсэхийг харгалзахгүйгээр хамруулна.

**Хотын хүн амд:** Улаанбаатар хот, аймгийн төв, тосгонд оршин суугаа хүн амыг хамруулна.

**Хөдөөгийн хүн амд:** Сумын төв, хөдөө нутагт амьдарч байгаа хүн амыг хамруулна.

**Бүтэн ба хагас өнчин хүүхдэд:** Эцэг эх нь хоёулаа нас барсан хүүхдийг бүтэн өнчинд, эцэг, эх хоёрын аль нэг нь нас барсан хүүхдийг хагас өнчинд тооцно.

**Төрөх үеийн хүйсийн харьцаа:** Энэ нь төрсөн эрэгтэй хүүхдийн тоог төрсөн эмэгтэй хүүхдийн тоонд харьцуулсан харьцаа юм.

**Төрөлтийн ерөнхий коэффициент:** Энэ нь 1000 хүн ам тутамд ноогдох тухайн жилд төрсөн амьд хүүхдийн тоог илэрхийлдэг бөгөөд түүнийг тооцохдоо амьд төрсөн хүүхдийн тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулж 1000-аар үржүүлдэг.

**Төрөлтийн тусгай коэффициент:** Энэ нь нөхөн үржихүйн нас(15-49)-ны 1000 эмэгтэйчүүдэд ноогдох амьд төрөлтийн тоог илэрхийлдэг үзүүлэлт юм.

**Төрөлтийн нийлбэр коэффициент:** Энэ нь нэг эмэгтэй нөхөн үржихүйн нас (15-49)-ныхаа туршид төрүүлэх нийт хүүхдийн тоо.

**Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент:** Тухайн насны бүлгийн эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоог мөн насны бүлгийн эмэгтэйчүүдэд харьцуулсан харьцаа

**Нас баралтын хүйсийн харьцаа:** Энэ нь нас барсан эрэгтэй хүний тоог\_нас барсан эмэгтэй хүний тоонд харьцуулсан харьцаа юм.

**Нас баралтын ерөнхий коэффициент:** Энэ нь 1000 хүн ам тутамд ноогдох тухайн жилд нас барсан хүний тоог илэрхийлдэг бөгөөд түүнийг тооцохдоо нас барсан хүний тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулж 1000-аар үржүүлдэг.

**Гэрлэлт:** Тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгжид гэр бүл болсноо бүртгүүлсэн хүмүүсийг гэрлэсэнд тооцно.

**Гэрлэлтийн ерөнхий коэффициент:** Иргэний гэр бүлийн байгууллагад тухайн жилд бүртгүүлсэн гэр бүлийн тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулсан харьцааг илэрхийлсэн үзүүлэлт.

**Хүүхэдтэй гэр бүлгүй хүн ам:** Гэр бүлгүй, 16 хүртэл насны хүүхэдтэй эрэгтэй болон эмэгтэй хүнийг эцэг, эх, хамаатан садангийн хэнтэй амьдарч байгааг харгалзахгүйгээр хамруулж тооцно.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо:** Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн хамгааллын тухай хуулийн 3-р зүйлд: Бие бялдар оюун ухааны чадавхи нь удамшлын болон удамшлын бус шалтгаан, төрөлхийн гажиг, өөрчлөлт, өвчин тарилгын дараах хүндрэл, осол гэмтлийн улмаас алдагдаж, хэвийн нөхцөлд хөдөлмөрлөх чадваргүй болсон, хараа, сонсгол, хэл ярианы болон бие эрхтэний тахир дутуу, оюун санааны хомсдол, сэтгэгцийн өөрчлөлттэй болох нь тогтоогдсон Монгол Улсын иргэн, Монгол улсад хууль ёсоор байнга оршин суугаа гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг тахир дутуу хүн гэж тодорхойлсон бөгөөд хөдөлмөр магадлах комиссоор тахир дутуу болох нь тогтоогдсон хүнийг авч бүртгэнэ.

## БҮЛЭГ 1. ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ

### 1.1. Хүн амын тооны өсөлт, өөрчлөлт

Сүхбаатар аймгийн суурин хүн ам 2012 оны жилийн эцсийн байдлаар 55.6 мянга болж, 2011 оныхоос 520 хүн буюу 0.9 хувиар өссөн бол 2005 оныхоос 2.9 мянган хүн буюу 5.4 хувиар, 2009 оныхоос 1.3 мянган хүн буюу 2.4 хувиар, тус тус өссөн байна. Хэдийгээр хүн амын тооны хувьд ингэж өссөн хэдийч өсөлтийн хурд төдийлөн тогтвортой байж чадаагүй байна. Манай аймгийн хувьд сүүлийн жилүүдэд хүн амын өсөлтийн хурд харьцангуй тогтвортой өсөх хандлагатай байна.

ЗУРАГ 1.1. ХҮН АМЫН ТОО, ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТИЙН ХУВЬ,  
2005-2012 ОН



Хүн амын өсөлтөнд төрөлт, нас баралт, гадаад шилжих хөдөлгөөн гэсэн гурван үндсэн хүн ам зүйн үзүүлэлт шууд нөлөөлдөг. 2012 онд хүн ам жилд дунджаар 0.9 хувиар өссөн нь өнгөрсөн оныхоос 0.4 пунктээр өссөн харагдаж байна.

## ХҮСНЭГТ 1.1. ХҮН АМЫН ТОО, БАЙРШЛААР, СУМААР, 2008-2012 ОН

Сум	2008		2009		2010		2011		2012	
	Аймаг, сумын төв	Хөдөө	Аймаг, сумын төв	Хөдөө	Аймаг, сумын төв	Хөдөө	Аймаг, сумын төв	Хөдөө	Аймаг, сумын төв	Хөдөө
Ас	445	1 330	538	1 268	666	1 132	623	1 134	652	1 100
Бд	1 158	3 402	1 169	3 399	1 214	3 377	1 328	3 277	1 277	3 337
Да	919	1 965	639	2 214	607	2 276	787	2 059	1 013	1 843
Мх	1 192	3 143	1 189	3 024	1 184	3 030	1 215	3 076	1 672	2 597
На	320	1 146	336	1 141	345	1 148	366	1 160	380	1 170
Он	1 261	2 377	1 261	2 385	1 229	2 369	1 225	2 383	659	2 996
Сү	639	2 624	631	2 566	638	2 506	643	2 503	1 101	2 077
Тш	608	2 427	610	2 420	630	2 431	634	2 408	885	2 132
Уб	758	2 252	766	2 117	755	2 111	741	2 086	981	1 799
Ха	542	1 080	566	1 032	581	1 019	592	991	600	996
Эц	2 691	3 618	2 813	3 626	2 889	3 594	2 916	3 558	2 943	3 584
Тц	1 063	1 276	1 106	1 298	1 070	1 317	1 055	1 331	1 349	1 042
Бу	12 944	2 605	13 859	2 390	14 297	2 437	14 755	2 282	14 917	2 546
Дүн	24 540	29 245	25 483	28 880	26 105	28 747	26 880	28 248	28 429	27 219

Аймгийн суурин хүн ам Баяндэлгэр, Мөнххаан, Эрдэнэцагаан, Баруун-Урт зэрэг сумдуудаар дийлэнх нь суурьшин амьдарч байна. Нийт хүн амын 51.2 хувь нь аймаг, сумын төвд амьдарч байгаа нь 2011 оныхоос 5.8 хувиар өссөн байна.

## ХҮСНЭГТ 1.2. ӨРХИЙН ТОО, БАЙРШЛААР, СУМААР, НЭГ ӨРХӨД НООГДОХ ХҮНИЙ ТОО, 2008-2012 ОН

Сум	2008		2009		2010		2011		2012		Нэг өрхөд ноогдох хүний тоо
	Аймаг, сумын төв	Хөдөө	Аймаг, сумын төв	Хөдөө	Аймаг, сумын төв	Хөдөө	Аймаг, сумын төв	Хөдөө	Аймаг, сумын төв	Хөдөө	
Ас	142	338	158	326	193	284	187	292	189	289	3.7
Бд	307	852	316	867	335	884	374	864	363	881	3.7
Да	288	515	199	599	191	617	238	554	302	505	3.5
Мх	323	868	328	872	331	884	340	890	495	755	3.4
На	92	298	100	304	103	308	111	313	114	315	3.6
Он	335	614	345	624	345	617	354	625	197	784	3.7
Сү	173	696	177	703	176	693	178	697	298	611	3.5
Тш	165	643	173	650	175	667	180	677	262	609	3.5
Уб	207	568	217	574	210	582	219	579	285	508	3.5
Ха	147	295	160	281	166	278	169	277	178	282	3.5
Эц	683	881	754	901	781	909	798	924	808	933	3.7
Тц	335	373	339	388	329	396	332	405	428	310	3.2
Бу	3 735	747	4 141	695	4 317	715	4 520	670	4 542	741	3.3
Дүн	6 932	7 688	7 407	7 784	7 652	7 834	8 000	7 767	8 461	7 523	3.5

2012 онд нийт өрхийн тоо 15.9 мянга болж 2008 оноос 9.3 хувиар, 2009 оноос 5.2 хувиар, 2010 оноос 3.2 хувиар, 2011 оноос 1.4 хувиар тус тус өссөн байна. 2012 оны нийт өрхийн 52.9 хувь нь аймаг, сумын төвийн өрх, 47.1 хувь нь хөдөөгийн өрх эзэлж байна. Аймгийн дунджаар нэг өрхөд 3.5 хүн ноогдож байна. 2000-2012 оны хүн амын динамикаас харахад 2000-2006 он хүртэл хүн ам буурч, 2007 оноос аажим, аажимаар өссөн байна. Хөдөө суурьшин мал маллан амьдардаг өрхийн тоо 6.5 мянга болж урьд оноос 4.4 %-иар буурсан ба жилийн 4-н улиралд малаа малладаг малчдын тоо 2012 онд 13.9 мянга болж 2011 оныхоос 6.2 хувиар буурсан байна. Жилийн 4-н улиралд малаа малладаг малчдын тоо жилээс жилд буурч байна.

### ХҮСНЭГТ 1.3. ХҮН АМЫН ТОО, ХҮН АМ ЗҮЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, СУМААР, 2012 ОН


Сум	Байнга хүн ам	Үүнээс:		Хүйсийн харьцаа	Хүн ам зүйн ачаалал	Дүнд эзлэх хувь	
		Эрэгтэй	Эмэгтэй			Эрэгтэй	Эмэгтэй
Ас	1 752	878	874	100.5	43.6	50.1	49.9
Бд	4 614	2 320	2 294	101.1	49.5	50.3	49.7
Да	2 856	1 431	1 425	100.4	48.0	50.1	49.9
Мх	4 269	2 133	2 136	99.9	51.9	50.0	50.0
На	1 550	778	772	100.8	40.8	50.2	49.8
Он	3 655	1 843	1 812	101.7	50.5	50.4	49.6
Сү	3 178	1 613	1 565	103.1	48.0	50.8	49.2
Тш	3 017	1 541	1 476	104.4	50.2	51.1	48.9
Уб	2 780	1 428	1 352	105.6	41.8	51.4	48.6
Ха	1 596	797	799	99.7	42.5	49.9	50.1
Эц	6 527	3 337	3 190	104.6	51.3	51.1	48.9
Тц	2 391	1 190	1 201	99.1	44.1	49.8	50.2
Бу	17 463	8 582	8 881	96.6	43.3	49.1	50.9
Дүн	55 648	27 871	27 777	100.3	46.6	50.1	49.9

Нийт хүн амын 50.1 хувь нь эрэгтэйчүүд, 49.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Хувийн жингээр эрэгтэй, эмэгтэйчүүд адилхан байна. 100 эмэгтэй тутамд ногдож буй эрэгтэйчүүдийн тоогоор илэрхийлэгддэг хүйсийн харьцаа нь сүүлийн жилүүдэд өсч байгаа нь эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өсөх хандлагатай байгааг харуулж байгаа юм. Сумдын хүн амын хүйсийн харьцааг харвал Түвшинширээ (104.4), Уулбаян (105.6), болон Эрдэнэцагаан (104.6) сумдад 100 эмэгтэйд 100-аас дээш эрэгтэй ноогдож байгаа бол Баруун-Урт (96.6), Түмэнцогт (99.1) сумдад 100 эмэгтэйд 96.6-99.9 эрэгтэй ноогдож байна. 2012 онд хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 100.3 байна.

Хүн ам зүйн ачаалал 2012 онд хөдөлмөрийн насны 100 хүнд 47 хүн ноогдож байна.




ЗУРАГ 1.2. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, 2008-2012 ОН



2012 оны нийт хүн амыг насны бүлгээр авч үзвэл 28.2 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 68.2 хувийг 15-64 насны хүн ам, 3.6 хувийг 65 ба түүнээс дээш насны өндөр настнууд эзэлж байна. Нийт хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь өндөр байх үеийг “Хүн ам зүйн цонх” гэдэг. Энэ үед улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эергээр нөлөөлдөг.

ЗУРАГ 1.3. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА 2010, 2012 ОН



Хүн амыг насны бүлгээр, хүйсээр, ингэхдээ хүн амын нас, хүйсийн суваргыг зурах сонгодог зарчмын дагуу эрэгтэйчүүдийг зүүн талд нь, эмэгтэйчүүдийг баруун талд нь, насыг доороос дээш өгсөх байдлаар абсолют тоогоор дүрслэн 2010, 2012 оны байдлаар харуулсан болно. Дээрх хүн амын нас, хүйсийн суваргыг харахад дунд хэсгээрээ аажмаар өргөсч байгаа нь хүн ам идэрших хандлагатай байгааг харуулж

байна. Суваргаас харвал 2012 онд 0-4 насны хүн амын тоо 5-9 насны хүн амын тооноос их байгаа нь төрөлтийн түвшин нэмэгдсэнтэй холбоотой. Мөн 20-34 насны хүн ам харьцангуй их, ерөнхийдөө хөдөлмөрийн насны хүн ам нэмэгдэж хүн ам зүйн цонхны үе үргэлжлэхийг харуулж байна.

**ХҮСНЭГТ 1.4. ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, СОНГОСОН ОНУУДААР**

Үзүүлэлт	2000	2002	2004	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Улсын дундаж										
Үүнээс:	63.2	63.5	64.6	65.9	66.5	67.2	68.0	68.1	68.3	68.7
Эрэгтэй	60.4	60.8	61.6	62.6	63.1	63.7	64.3	64.9	64.7	64.9
Эмэгтэй	66.1	66.5	67.8	69.4	70.2	71.0	71.8	72.3	73.8	74.3
Сүхбаатар	64.3	64.6	65.5	66.7	67.3	68.0	68.8	68.9	70.0	70.8

Хүн амын улсын дундаж наслалтыг харвал 2012 онд 68.7 болж өмнөх оныхоос 0.4 пунктээр нэмэгдсэн бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 74.3, эрэгтэйчүүдийнх 64.9 болсон байна. 2012 оны байдлаар Сүхбаатар аймгийн дундаж наслалт 70.8 болж улсын дунджаас 2.1 насаар өндөр байна.

**ХҮСНЭГТ 1.5. ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ 1000 ХҮН АМД НООГДОХ ХҮҮХЭД, ӨНДӨР НАСТАЙ ХҮНИЙ ТОО, СУМААР, 2012 ОН**

Сум	Хөдөлмөр ийн насны хүн ам	Хүүхэд	Өндөр настан	Бүгд	Хөдөл/насны хүн ам		
					Хүүхэд	Өндөр настан	Аг аа
Ас	1 220	469	63	532	384	52	469
Бд	3 087	1 366	161	1 527	443	52	533
Да	1 930	815	111	926	422	58	517
Мх	2 811	1 280	178	1 458	455	63	519
На	1 101	395	54	449	359	49	445
Он	2 429	1 091	135	1 226	449	56	505
Сү	2 147	937	94	1 031	436	44	480
Тш	2 008	906	103	1 009	451	51	502
Уб	1 960	727	93	820	371	47	418
Ха	1 120	406	70	476	363	63	425
Эц	4 313	2 058	156	2 214	477	36	513
Тц	1 659	639	93	732	385	56	441
Бу	12 185	4 597	681	5 278	377	56	433
Дүн	37 970	15 686	1 992	17 678	413	52	466

Хөдөлмөрийн насны хүн ам нийт хүн амын 68.2 хувийг эзэлж, 28.2 хувийг хүүхэд, 3.6 хувийг өндөр настан эзэлж байна. Хөдөлмөрийн насны 1000 хүнд 413 хүүхэд, 52 өндөр настанг асран тэжээх үүрэг ногдож байна.

ХҮСНЭГТ 1.6. НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2005-2012 ОН

Үзүүлэлтүүд	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	$\frac{2012}{2011}$ %
16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо	816	588	577	393	143	207	125	251	200.8
16 хүртэлх насны хүүхэдтэй гэр бүлгүй эмэгтэйчүүд	820	695	667	640	601	666	587	652	111.1
Өрх толгойлсон эмэгтэй	1 333	1 324	1 452	1 708	1 910	1 845	2 118	2 216	104.6
Олон ам бүлтэй өрх	451	350	311	237	208	170	149	119	79.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	1 882	1 768	1 629	1 988	2 220	2 248	2 516	2 599	103.3
Хагас өнчин хүүхдийн тоо	1 099	1 145	1 037	1 044	901	775	683	696	101.9
Бүтэн өнчин хүүхдийн тоо	63	67	68	70	52	52	53	44	83.0

16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 2012 онд 251 буюу нийт өрхийн 1.6 хувийг эзэлж байна.

16 хүртэлх насны хүүхэдтэй, гэр бүлгүй эмэгтэйчүүдийн тоо 2012 онд 652 болж урьд оныхоос 11.1 хувиар өссөн байна.

Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 2012 онд 2.2 мянга болж 2008 оныхоос 29.7 хувь, 2009 оныхоос 16 хувь, 2010 оныхоос 20.1 хувь, 2011 оныхоос 4.6 хувиар тус тус өссөн байна.

Өнчин хүүхдийн тоо 740 болж, нийт хүн амын 1.3 хувийг эзэлж байна. Энэ нь 2008 оныхоос 33.6 хувь, 2009 оныхоос 22.4 хувь, 2010 оныхоос 10.5 хувиар тус тус буурч, 2011 оныхоос 1.9 хувиар өссөн байна.

Бүтэн өнчин хүүхэд нийт хүн амын 0.1 хувь, хагас өнчин хүүхэд 1.3 хувийг тус тус эзэлж байна.


Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2012 онд 2599 болж урьд оныхоос 3.3 хувиар өссөн байна.

## БҮЛЭГ 2. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН

### 2.1. Төрөлт, нас баралт, цэвэр өсөлт

Төрөлтийн ерөнхий коэффициент (ТЕК) 2003 онд 32.7, 2005 онд 17.6 болж буурч байсан хэдий ч 2006 оноос тогтмол өсч 2012 онд 24.4 болсон байна. Нас баралтын ерөнхий коэффициент 2012 онд 6.4 болж урьд оныхоос 2.3 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 2.1. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ЦЭВЭР ӨСӨЛТ 1000 ХҮНД НОГДОХООР, 2007-2012 ОН



ХҮСНЭГТ 2.1. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2007-2012 ОН

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2007	2008	2009	2010	2011	2012
Төрсөн хүүхдийн тоо	Тоо	1 122	1 131	1 253	1 218	1 494	1 375
Насбарсан хүний тоо	Тоо	349	332	332	350	478	357
Цэвэр өсөлт	Тоо	773	799	921	868	1 016	1 018
Тухайн жилийн дундаж хүн ам	Тоо	52 487	53 164	54 074	54 608	54 990	55 388
15-49 насны эмэгтэйчүүдийн тоо	Тоо	15 497	15 890	15 955	15 913	15 869	15 834
Төрөлтийн ерөнхий коэффициент	коэф	21.4	21.3	23.2	22.3	27.2	24.4
Төрөлтийн тусгай коэффициент	коэф	72.4	71.2	78.5	76.5	94.1	86.8
Нас баралтын ерөнхий коэффициент	коэф	6.6	6.2	6.1	6.4	8.7	6.4

2006 оноос эхлэн хүүхдийн мөнгө хөтөлбөр, 18 нас хүртэлх хүүхдийн мөнгөн тэтгэмж, шинэ төрсөн хүүхэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан 2006 оноос эхлэн төрөлтийн түвшин нэмэгдэж 2012 онд 1375 болж 2007 оноос 22.5

хувь, 2009 оноос 9.7 хувиар тус тус өсч, 2011 оноос 7.9 хувиар буурсан байна. Манай аймгийн хүн амын төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 102 хөвгүүн ногдож байна. Нас баралтын ерөнхий коэффициент 2012 онд 6.4 болж 2011 оноос 2.3 пунктээр буурсан байна.

## ХҮСНЭГТ 2.2. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, СУМААР, 2008-2012 ОН

Сум	Төрөлт					Нас баралт				
	2008	2009	2010	2011	2012	2008	2009	2010	2011	2012
Ас	43	37	32	39	38	7	5	11	9	19
Бд	95	117	92	129	103	27	19	34	27	34
Да	47	62	62	63	57	20	15	16	31	16
Мх	87	77	98	139	113	29	20	36	33	33
На	30	29	31	37	42	10	6	11	12	6
Он	73	86	76	103	91	20	29	24	21	15
Сү	69	80	67	101	77	18	17	17	34	16
Тш	65	67	77	89	51	21	19	15	22	23
Уб	45	35	50	56	47	22	12	14	15	14
Ха	80	70	54	90	57	23	14	13	18	21
Эц	36	31	34	38	37	10	6	7	8	6
Тц	113	154	168	165	169	38	46	34	56	35
Бу	348	408	377	445	493	91	106	118	192	119
Дүн	1 131	1 253	1 218	1 494	1 375	336	314	350	478	357

Хүн амын тоо механик хөдөлгөөнөөс гадна ердийн хөдөлгөөнөөс шалтгаалан байнга өөрчлөгдөж байдаг. Манай аймгийн хувьд 2003 онд 1000 хүнд ногдох төрөлтөөр хамгийн өндөр байсан ба улсын дундажтай харьцуулахад 14.3 промилээр өндөр байжээ. Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд 2012 онд 28 болж 2010 оноос 12 хувь, 2011 оноос 16.7 хувиар тус тус өссөн байна. 5 хүртэл насандаа эндсэн хүүхэд 2012 онд 5 болж урьд оноос 37.5 хувиар буурсан байна.


2012 онд халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 715 болж урьд оноос 9.7 хувиар өссөний дотор гахайн хавдар, тэмбүү, трихоминиаз, салхинцэцэг зэрэг өвчлөлтүүд өссөн байна.

## 2.2. ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТ, ҮРЧЛЭЛТ

### ГЭРЛЭЛТ

Нийт 360 хос 2012 онд гэрлэлтээ бүртгүүлж, 26 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 42 хүүхэд үрчлэгджээ. Гэрлэлт урьд оноос 19.6 хувиар өсч, гэр бүл цуцлалт 21.2 хувь, хүүхэд үрчлэлт 20.8 хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 2.2 1000 ХҮНД НОГДОХ ГЭРЛЭЛТ, 2006-2012 ОН



1000 хүнд ногдох гэрлэлт 2010 онд огцом буурч, 11.6-аас 4.4 болсон бол 2012 онд 6.5 болж урьд оноос 1 пунктээр нэмэгдсэн байна. 1000 хүн амд ногдох гэрлэлт 2003 оноос 2004 онд буурч, харин 2005 онд эргээд өсөх хандлагатай болсон ба 2006 оноос эхлэн “Шинэ гэр бүл бологсод” хөтөлбөрийн хүрээнд шинээр гэр бүл бологчдод нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгож эхэлсэнтэй холбоотойгоор гэрлэлт нэмэгдэж 2006 онд 1.4 мянгад хүрсэн хэдий ч 2007 оноос тасралтгүй буурч 2012 онд 360 болжээ.

ХҮСНЭГТ 2.3. ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТ, ҮРЧЛЭЛТ, 2007-2012 ОН

Үзүүлэлтүүд	2007	2008	2009	2010	2011	2012
Гэрлэлт	877	624	626	239	301	360
Цуцлалт	12	18	25	20	33	26
Үрчлэлт	41	34	55	51	53	42
Гэрлэлтийн ерөнхий коэффициент	16.7	11.7	11.6	4.4	5.5	6.5
Гэрлэлтийн тусгай коэффициент	23.3	16.1	16.0	6.0	7.6	9.0


Гэрлэлтийн ерөнхий коэффициент 6.5 байгаа нь ойролцоогоор мянган хүн тутмын 6 нь гэрлэснийг харуулж байна. 1000 хүнд ногдох гэрлэлт 2012 онд 2011 оноос 1 промилээр өссөн байна.

Гэрлэлтийн тусгай коэффициентээр гэрлэх насны 1000 хүн тутамд ногдох гэрлэлтийн тоог харуулдаг. 2011 онд 9 болж урьд оноос 1.4 промилээр өссөн байна. Өөрөөр хэлбэл гэрлэх насны 1000 хүн тутмаас 9 хүн гэрлэсэн байна.

## ЦУЦЛАЛТ

Гэр бүл цуцлалт нь хүн амын ердийн хөдөлгөөний бас нэг үзүүлэлт юм.


ЗУРАГ 2.3. 1000 ХҮНД НОГДОХ ЦУЦЛАЛТ, 2006-2012 ОН



Цуцалсан гэр бүлийн тоо 2012 онд урьд оноос 0.1 промилээр буурсан нь дээрх графикаас харагдаж байна.

## Үрчлэлт

ЗУРАГ 2.4. 1000 ХҮНД НОГДОХ ҮРЧЛЭЛТ, 2007-2012 ОН



2012 онд 1000 хүнд ноогдох үрчлэлт 0.8 болж урьд оноос 0.2 промилээр буурсан байна.

## БҮЛЭГ 3. ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДЛӨГӨӨН

### 3.1 Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал

Хүн амын шилжих хөдөлгөөн нь төрөлт, нас баралтын нэг адил хүн амын өсөлт өөрчлөлтийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд уугуул нутгийн хүн амын өөрчлөлтийг газар зүйн нэгжүүдээр тодорхойлж, хүн амын хөдөлгөөнийг судалдаг.

#### ХҮСНЭГТ 3.1. ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН


Сумд	Шилжиж ирсэн					Шилжиж явсан						
	Бүгд	Улаан-баатар	Дорнод	Дорноговь	Бусад	Улаан-баатар	Дорнод	Хэнтий	Дорноговь	Бусад	Бүгд	
Ас	3	2			1	13		1	2		16	
Бд	12	6		3	3	23	36	1		5	65	
Да	10	3	2	1	4	20	1		4	8	33	
Мх	32	11	1	1	19	48	3	17	2	4	74	
На	4	2		1	1	15					15	
Он	22	9	7	1	5	35	3	1	11	9	59	
Сү	16	4	7		5	20	6				26	
Тш	21	6		8	7	34	2	15	9		60	
Уб	11	9		1	1	43		8		1	52	
Ха	7	6			1	7	6				13	
Эц	29	13	15		1	29	12		4	5	50	
Тц	14	14					1	9	1	30	41	
Бу	183	132	19	12	20	174	26	5	11	27	243	
<b>Дүн</b>	<b>364</b>	<b>217</b>	<b>51</b>	<b>28</b>	<b>68</b>	<b>461</b>	<b>96</b>	<b>57</b>	<b>44</b>	<b>89</b>	<b>747</b>	
Урьд онууд	2011	530	252	81	69	128	675	121	123	62	187	1 168
	2010	635	314	86	50	185	1 063	90	119	79	69	1 420
	2009	514	235	83	59	137	862	157	192	84	114	1 409
	2008	414	212	58	53	91	901	75	199	161	81	1 417
	2000-2012	3 175	1 444	581	349	801	10 157	1 143	1 818	1 176	798	15 092

2012 оны жилийн эцэст 364 хүн шилжин ирж, урьд оныхоос 31 хувиар, 747 хүн шилжин явж 36 хувиар тус тус буурсан байна. Нийт шилжин ирсэн хүн амын 217 хүн буюу 40.4 хувь нь УБ хотоос шилжин ирсэн байна. Шилжин явсан хүн амын байдлаас харахад 62 хувь нь Улаанбаатар хот руу шилжсэн байна.

2000-2012 онуудын нийт шилжин ирэгсдээс Улаанбаатар (45.5%), Дорнод (18.3%), Дорноговь (10.9%), бусад (25.3%) аймгаас ирж суурьшсан, харин шилжин явагсдаас Улаанбаатар хот (67.3%), Хэнтий (12%), Дорноговь (7.8%) Дорнод (7.6%), бусад (5.3%) аймгууд руу шилжсэн байна. Сумдаар нь авч үзвэл Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Эрдэнэцагаан, Баруун-Урт зэрэг сумдуудад шилжилт хөдөлгөөн бусад сумдаас өндөр байна.



ЗУРАГ 3.1. ХҮН АМЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН, 2000-2012 ОН



### 3.2 ШИЛЖИН ИРЭЛТ

2012 оны жилийн эцсийн байдлаар нийт шилжин ирэгчдийн талаас илүү хувь нь Улаанбаатар хотоос шилжин иржээ. Хүн ам зүйн судалгааны шилжих хөдөлгөөнтэй холбоотой чухал үзүүлэлтүүдийн нэг нь шилжин ирэлтийн коэффициент юм.

ЗУРАГ 3.2. ШИЛЖИН ИРСЭН ХҮНИЙ ТОО, ШИЛЖИН ИРЭЛТИЙН КОЭФФИЦИЕНТ, 2006-2012 ОН




Шилжин ирэлтийн коэффициент нь 1000 хүнд ногдох шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо бөгөөд 2006-2010 онд аажмаар өсч, 2011 онд 1.0, 2012 онд 0.7 болж буурсан байна.

### 3.3 Шилжин явалт

2012 оны жилийн эцэст 747 хүн байнга оршин суудаг засаг захиргааныхаа нэгжээс шилжин явсан байна. Хүн ам зүйн судалгааны шилжих хөдөлгөөнтэй холбоотой чухал үзүүлэлтүүдийн нэг нь шилжин явалтын коэффициент юм. Энэ үзүүлэлт нь 1000 хүнд ногдох шилжин явагчдын тоо бөгөөд 2012 оны эцэст 1000 хүн тутмын 13 нь байнга оршин сууж байсан засаг захиргааны нэгжээсээ шилжин явсан нь 2006 оныхоос 13.4 пунктээр, 2008 оныхоос 13.2 пунктээр, 2010 оныхоос 12.5 пунктээр тус тус буурсан байна.


ЗУРАГ 3.3. ШИЛЖИН ЯВСАН ХҮНИЙ ТОО, ШИЛЖИН ЯВАЛТЫН КОЭФФИЦИЕНТ, 2006-2012 ОН



### 3.4. Хүн амын цэвэр шилжих хөдөлгөөн

Цэвэр шилжих хөдөлгөөн нь шилжих хөдөлгөөний гол үзүүлэлт юм. Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент нь (ШХЦК) нь шилжин ирэлтийн коэффициент болон шилжин явалтын коэффициентийн ялгавраар илэрхийлэгдэнэ.

ЗУРАГ 3.4. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ЦЭВЭР КОЭФФИЦИЕНТ, 2006-2012 ОН



ШХЦК нь 2006 онд 26.6 байсан бол 2012 онд 12.8 болж буурсан байна. 2006-2012 онуудад Сүхбаатар аймгийн шилжин явалт нь шилжин ирэлтээсээ илүү байна.

## ДҮГНЭЛТ

Сүхбаатар аймгийн суурин хүн ам 2012 оны жилийн эцсийн байдлаар 55.6 мянга болж, 2011 оныхоос 520 хүн буюу 0.9 хувиар өссөн байна. Нийт хүн амын 50.1 хувь нь эрэгтэйчүүд, 49.9 хувь нь эмэгтэйчүүд байна. 2012 онд хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 100.3 байна. Хөдөлмөрийн насны хүн ам нийт хүн амын 68.2 хувийг эзэлж, 28.2 хувийг хүүхэд, 3.6 хувийг өндөр настан эзэлж байна.

2012 онд нийт өрхийн тоо 15.9 мянга болж 2011 оноос 1.4 хувиар өссөн байна. 2012 оны нийт өрхийн 52.9 хувь нь аймаг, сумын төвийн өрх, 47.1 хувь нь хөдөөгийн өрх эзэлж байна. Аймгийн дунджаар нэг өрхөд 3.5 хүн ноогдож байна.

Хөдөө суурьшин мал маллан амьдардаг өрхийн тоо 6.5 мянга болж урьд оноос 4.4 %-иар буурсан ба жилийн 4-н улиралд малаа малладаг малчдын тоо 2012 онд 13.9 мянга болж 2011 оныхоос 6.2 хувиар буурсан байна. Жилийн 4-н улиралд малаа малладаг малчдын тоо жилээс жилд буурч байна.

Төрөлтийн ерөнхий коэффициент (ТЕК) 2003 онд 32.7, 2005 онд 17.6 болж буурч байсан хэдий ч 2006 оноос тогтмол өсч 2012 онд 24.4 болсон байна.

2006 оноос эхлэн төрөлтийн түвшин нэмэгдэж 2012 онд 1375 болж 2007 оноос 22.5 хувь, 2009 оноос 9.7 хувиар тус тус өсч, 2011 оноос 7.9 хувиар буурсан байна. Манай аймгийн хүн амын төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 102 хөвгүүн ногдож байна.

Нас баралтын ерөнхий коэффициент 2012 онд 6.4 болж урьд оныхоос 2.3 пунктээр буурсан байна.

Нийт 360 хос 2012 онд гэрлэлтээ бүртгүүлж, 26 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 42 хүүхэд үрчилж авчээ. Гэрлэлт урьд оноос 19.6 хувиар өсч, гэр бүл цуцлалт 21.2 хувь, хүүхэд үрчлэлт 20.8 хувиар тус тус буурсан байна.

2012 оны жилийн эцэст 364 хүн шилжин ирж, урьд оныхоос 31 хувиар, 747 хүн шилжин явж 36 хувиар тус тус буурсан байна. Хүн амын дотоод шилжих хөдөлгөөн нийслэл болон томоохон хот, суурин газар руу чиглэх болсон нь төр засгийн анхаарлын төвд байх ёстой асуудлын нэг болоод байна. Мөн хөдөлмөрийн насны хүн амын тоо нэмэгдэж байгаа нь ажилгүйдлийг өсгөхийн зэрэгцээ ажлын байр хайн хот суурин газар руу шилжигчдийн тоог өсгөсөөр байна.

### Танилцуулгын боловсруулсан арга зүй:

Статистикийн албан ёсны мэдээ, тайланд тулгуурлан холбогдох үзүүлэлтүүдийг тооцож, өмнөх онуудтай харьцуулан дүгнэж, статистикийн хүснэгт, зургаар харуулж танилцуулгыг хийлээ.

### Хамруулсан хугацаа:

Үзүүлэлтүүдийг ихэвчлэн 2008-2012 оноор, зарим шаардлагатай үзүүлэлтийг 2000-2012 оны байдлаар авч өсөлт өөрчлөлтийг харьцууллаа.

### Мэдээллийн эх үүсвэр:

- МУ-ын Статистикийн эмхтгэл-2012 он
- Суурин хүн амын жилийн тайлан (ХА-3)-2008-2012 он
- Өрх, хүн амын нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн тайлан (НС-1)-2012 он
- Аймгийн Статистикийн бюллетень-2012 он
- Статистикийн салбарт мөрдөж ажиллах аргачлалын эмхтгэл
- Хүн амын үзүүлэлтийг тооцох аргачлал, түүнийг ашиглах гарын авлага

## ХАВСРАЛТ 1.1 СУУРИН ХҮН АМ /бүгд/

/2012 оны эцэст, насны бүлгээр/

Сумд	Бүгд	Насны бүлгээр											
		0-4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
Баруун-Урт	17 463	1 972	309	277	250	246	230	258	275	269	264	247	248
Асгат	1 752	184	31	28	20	34	33	23	16	25	34	41	36
Баяндэлгэр	4 614	516	90	73	76	71	104	79	86	85	89	97	79
Дарьганга	2 856	286	44	41	45	46	57	59	56	61	59	61	51
Мөнххаан	4 269	480	88	85	73	78	66	83	67	85	75	100	88
Наран	1 550	168	19	16	16	17	19	22	31	36	17	34	30
Онгон	3 655	426	56	49	75	50	62	76	66	72	79	80	72
Сүхбаатар	3 178	365	68	52	41	55	56	51	51	71	62	65	70
Түвшинширээ	3 017	329	58	49	50	52	43	53	45	71	80	76	51
Түмэнцогт	2 391	243	31	40	30	45	37	39	37	53	43	41	48
Уулбаян	2 780	305	51	34	32	45	41	41	43	41	41	53	66
Халзан	1 596	169	14	14	22	19	19	20	32	28	37	32	34
Эрдэнэцагаан	6 527	753	155	131	131	123	112	130	108	117	150	148	128
Дүн	55 648	6 196	1 014	889	861	881	879	934	913	1 014	1 030	1 075	1 001

Сумд	Насны бүлгээр												
	16	17	18	19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60+
Баруун-Урт	284	287	313	277	1 991	1 729	1 527	1 278	1 118	1 082	932	704	1 096
Асгат	44	26	30	39	194	151	141	132	132	108	94	65	91
Баяндэлгэр	101	88	93	81	493	369	423	372	319	238	214	141	237
Дарьганга	65	54	49	45	285	221	246	264	220	170	134	78	159
Мөнххаан	82	81	74	79	451	403	389	329	255	207	178	122	251
Наран	37	34	37	25	154	146	114	125	120	108	97	45	83
Онгон	64	62	74	55	338	303	310	339	256	200	183	113	195
Сүхбаатар	63	81	64	52	335	286	291	227	211	187	136	99	139
Түвшинширээ	78	59	44	46	309	298	288	241	178	137	123	99	160
Түмэнцогт	46	56	48	43	280	187	220	169	140	157	132	87	139
Уулбаян	59	60	66	51	302	266	232	207	188	170	143	87	156
Халзан	30	35	27	34	158	149	132	139	125	109	67	50	101
Эрдэнэцагаан	124	134	118	98	690	650	595	484	389	306	318	191	244
Дүн	1 077	1 057	1 037	925	5 980	5 158	4 908	4 306	3 651	3 179	2 751	1 881	3 051

## ХАВСРАЛТ 1.2 ХҮН АМЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2012 ОН

1 Нийт хүн ам	55648
2 Хүн амын жилийн дундаж өсөлт	0.9
3 Хүн амын тоо, хүйсээр	
- Эрэгтэй	27871
- Эмэгтэй	27777
4 Аймаг, сумын төвийн хүн ам	28429
5 Хөдөөгийн нийт хүн ам	27219
6 Улсын хүн амын тоо, бүсээр, мян.хүн	
- Баруун	361.0
- Хангай	530.2
- Төв	467.0
- Зүүн	191.4
- Улаанбаатар	1318.1
7 Өрхийн тоо	15984
- Аймаг сумын төвийн өрх	8461
- Хөдөөгийн өрх	7523
8 Хүн амын тоо, насны бүлгээр	
- Хүүхэд (0-14)	15686
- Хөдөлмөрийн насны хүн ам (15-59 настай хүн ам)	36911
- Өндөр настай хүн ам (60-69 настай хүн ам)	1688
- Хөгшин настай хүн ам (70 ба түүнээс дээш настай хүн ам)	1363
- Нөхөн үржихүйн насны эмэгтэй хүн амын (15-49 насны эмэгтэй хүн ам)	15834
- Сонгуулийн насны хүн ам (18 ба түүнээс дээш настай хүн ам)	36827
- Өсвөр насны хүн ам (10-19 насны хүн ам)	
Эрэгтэй	5099
Эмэгтэй	4964
9 Төрөлтийн ерөнхий коэффициент	24.4
10 Нас баралтын ерөнхий коэффициент	6.4
11 Улсын дундаж наслалт	68.7
- Эрэгтэй	64.9
- Эмэгтэй	74.3
12 Аймгийн дундаж наслалт	70.8
13 Хүн ам зүйн ачаалал	46.6
- Хүүхдийн ачаалал	41.3
- Өндөр настны ачаалал	5.3

## ХАВСРАЛТ 1.3 ХҮН АМ, ӨРХИЙН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

## а. Өрхийн үзүүлэлт, аймгийн дүн, өрхөөр

1	үзүүлэлт	2011		2012	
		тоо	Нийт өрхөд эзлэх %	тоо	Нийт өрхөд эзлэх %
1	Аймгийн нийт өрхийн тоо	15 767	100.0	15 984	100.0
2	Байршил: Аймаг, сумын төвд	8 000	50.7	8 461	52.9
	Хөдөө	7 767	49.3	7 522	47.1
3	Сууцны төрлөөр: Гэрт	11 422	72.4	11 371	71.1
	Байшинд	4 345	27.6	4 613	28.9
4	Сууцны нөхцөл: Тохилог сууцанд	881	5.6	1 106	6.9
	Сууцны тусдаа байшинд	2 578	16.4	2 985	18.7
	Гэр сууцанд	11 422	72.4	11 371	71.1
	Нийтийн байранд	513	3.3	499	3.1
	Орон сууцны бус	23	0.1	23	0.1
5	Халаалтын төрлөөр: Төвлөрсөн	1 185	7.5	1 322	8.3
	Төвлөрсөн бус	455	2.9	287	1.8
	Бусад	14 127	89.6	14 375	89.9
6	Цахилгаан хангамж: Төвлөрсөн	7 879	50.0	8 337	52.2
	Орон нутгийн төвлөрсөн	-	-	-	-
	Бусад	7 207	45.7	7 583	47.4
	Байхгүй	681	4.3	64	0.4
7	Усан хангамж:Халуун,хүйтэн устай	211	1.3	455	2.8
	Зөвхөн хүйтэн устай	15 556	98.7	15 529	97.2
	Үүнээс: Төвлөрсөн	1 057	6.7	847	5.3
	Бие даасан систем	-	-	-	-
	Зөөврийн	14 499	92.0	14 682	91.9
8	Хатуу хог, хаягдал зайлуулалт:				
	Үйлчилгээний байгууллагаар	x	x	5 719	35.8
	Зөвшөөрөгдсөн цэгт	x	x	2 609	16.3
	Тогтсон цэггүй	x	x	7 656	47.9
9	Тээврийн хэрэгсэлтэй өрх	5 647	35.8	6 897	43.1
10	Компьютертэй өрх	x	x	1 336	8.4
11	Интернэт хэрэглэдэг өрх	x	x	341	2.1

**Тодотгол:** Хүн амын цахим мэдээллийн сангийн 2012 оны жилийн эцсийн зарим үзүүлэлтээс



## б. Хүн амын үзүүлэлт, аймгийн дүн, хүнээр

№	үзүүлэлт	2011		2012	
		тоо	Нийт хүнд эзлэх %	тоо	Нийт хүнд эзлэх %
1	Аймгийн нийт хүн амын өй	55 128	100.0	55 648	100.0
2	Байршил: Аймаг, сумын төвд	26 880	48.8	28 429	51.1
	Хөдөө	28 248	51.2	27 219	48.9
3	Хүйс: Эрэгтэй	27 619	50.1	27 871	50.1
	Эмэгтэй	27 509	49.9	27 777	49.9
4	Хүйсийн харьцаа	100.4	-	100.3	-
5	Насны бүлэг: 0-4 настай	5 934	21.8	6 196	22.8
	5-14 настай	9 492	34.9	9 490	34.9
	15-34 настай	21 417	78.7	21 143	77.7
	35-59 настай	15 369	56.5	15 768	57.9
	60 ба дээш настай	2 913	10.7	3 051	11.2
	Үүнээс: 100 < настай	3	0.0	2	0.0
6	Хүн ам зүйн ачаалал	49.9	-	50.8	-
7	Боловсрол: 6-ааг < насаар:	х	х	48 436	100.0
	Дээд	х	х	4 382	9.0
	Тусгай мэргэжлийн дунд	х	х	1 957	4.0
	Мэргэжлийн анхан шат	х	х	1 764	3.6
	Бүрэн дунд	х	х	8 976	18.5
	Суурь боловсрол	х	х	12 845	26.5
	Бага боловсрол	х	х	10 289	21.2
	Боловсролгүй	х	х	8 223	17.0
8	Гэрлэлт: 16 ба < насаар:	38 616	100.0	38 960	100.0
	Гэрэлсэн	23 048	59.7	23 071	59.2
	Хамт амьдардаг	259	0.7	471	1.2
	Цуцалсан	365	0.9	377	1.0
	Бэлэвсэн	2 346	6.1	2 419	6.2
	Тусгаарласан	194	0.5	224	0.6
	Огт гэрлээгүй	12 404	32.1	12 398	31.8

**Тодотгол:** Хүн амын цахим сангийн зарим үзүүлэлтээс. Боловсролыг 2011 онд 7-оос дээш насаар гаргаж байсан.